



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ДАРХАН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2024 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/З/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.

**Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр**

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

**Аудитын менежер У.Батсүрэн**

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Батцэцэг**

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

**Ахлах аудитор С.Санжаажав**

Утас: 70378845 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn



Дархан-Уул аймаг

2025 он

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4.2 Худалдан авах ажиллагааны тухай .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
ДХЦЭХ	Дотоод хэрэглээний цахилгаан эрчим хүч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.12 № 149

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус станц нь 1965 онд ашиглалтад орсон 4 хуучин турбинд шаардлагатай сэлбэг, хэрэгслийг Оросын холбооны улсын Калуга турбины үйлдвэрт захиалж, 155,820.5 мянган төгрөг урьдчилан төлснийг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд 434.2 сая.кВт.ц ЦЭХ, 699.0 мян.Гкал ДЭХ боловсруулж, 373.0 сая.кВт.ц ЦЭХ, 678.8 мян.Гкал ДЭХ түгээсэн нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс ЦЭХ 1.6 хувиар, ДЭХ 4.5 хувиар тус тус өсөж, борлуулалтын орлого 5,919,991.1 мянган төгрөг буюу 8.6 хувиар нэмэгдэж, 3,939,336.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 86 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 95.4 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4525020254

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	332,930,593.94	327,079,804.91
1.1.2	Дансны авлага	3,343,605,873.82	3,928,276,619.17
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	473,679,929.71	374,064,687.33
1.1.4	Бусад авлага	191,517,408.14	954,124.61
1.1.6	Бараа материал	7,317,321,872.33	6,507,375,712.96
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	523,512,583.15	832,056,453.08
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>12,182,568,261.09</b>	<b>11,969,807,402.06</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	129,418,807,445.61	130,895,986,527.16
1.2.2	Биет бус хөрөнгө	25,288,408,451.70	25,036,455,896.67
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>154,707,215,897.31</b>	<b>155,932,442,423.83</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>166,889,784,158.40</b>	<b>167,902,249,825.89</b>
2.1.1.1	Дансны өглөг	5,136,457,500.38	3,825,314,582.57
2.1.1.2	Цалингийн өглөг	551,231,225.00	-
2.1.1.3	Татварын өр	29,068,828.06	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,500,000,000.00	1,595,971,189.51
2.1.1.6	Хүүний өглөг	-	10,096,164,604.86
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	2,991,999,508.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	85,553.47
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,216,757,553.44</b>	<b>18,509,535,438.41</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	80,548,254,520.77	63,753,302,659.67
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>80,548,254,520.77</b>	<b>63,753,302,659.67</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>87,765,012,074.21</b>	<b>82,262,838,098.08</b>
2.3.1	Төрийн өмч	10,040,100,005.47	9,992,637,872.43
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	71,884,437,391.18	74,507,202,298.57
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	23,699,196,000.00	23,699,196,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(26,498,961,312.46)	(22,559,624,443.19)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>79,124,772,084.19</b>	<b>85,639,411,727.81</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>166,889,784,158.40</b>	<b>167,902,249,825.89</b>





2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	71,992,043,066.58	22,603,140,000.00	(21,891,631,236.96)	82,743,651,835.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	10,040,100,005.47	71,992,043,066.58	22,603,140,000.00	(21,891,631,236.96)	82,743,651,835.09
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	(4,607,330,075.50)	(4,607,330,075.50)
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	1,096,056,000.00	-	1,096,056,000.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(107,605,675.40)	-	-	(107,605,675.40)
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,040,100,005.47	71,884,437,391.18	23,699,196,000.00	(26,498,961,312.46)	79,124,772,084.19
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	10,040,100,005.47	71,884,437,391.18	23,699,196,000.00	(26,498,961,312.46)	79,124,772,084.19
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	-	-	-	3,939,336,869.27	3,939,336,869.27
14	Өмчид гаргасан өөрчлөлт	(47,462,133.04)	2,718,692,751.46	-	-	2,671,230,618.42
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(95,927,844.07)	-	-	(95,927,844.07)
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	9,992,637,872.43	74,507,202,298.57	23,699,196,000.00	(22,559,624,443.19)	85,639,411,727.81



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	66,310,301,184.24	79,353,432,128.77
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	65,786,770,252.96	71,189,170,069.51
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	7,487,009,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	523,530,931.28	677,253,059.26
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	65,449,212,127.29	77,772,127,621.21
1.2.1	Ажиллагчдад төлсөн	12,743,571,551.90	16,512,272,604.83
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,532,031,543.92	5,206,580,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	19,405,017,412.25	18,237,038,612.06
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	25,888,350,900.00	30,336,129,600.32
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	49,314,665.92	963,281,031.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,817,601,755.79	6,382,767,816.41
1.2.9	Бусад мөнгөн зарлага	13,324,297.51	134,057,956.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	861,089,056.95	1,581,304,507.56
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,102,398.61	1,649,278.51
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,102,398.61	1,649,278.51
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,109,262,168.84	1,663,775,965.39
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,109,262,168.84	1,663,775,965.39
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,108,159,770.23)	(1,662,126,686.88)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,268,526,751.00	9,804,115,973.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,268,526,751.00	9,804,115,973.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,809,887,794.67	9,728,011,533.96
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	5,809,887,794.67	9,728,011,533.96
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,458,638,956.33	76,104,439.04
4	Валютын ханшийн зөрүү	610,203.92	(1,133,048.75)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	212,178,446.97	(5,850,789.03)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,752,146.97	332,930,593.94
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	332,930,593.94	327,079,804.91



## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2024		Зөрүү	Хувь	
			Батлагдсан төлөвлөгөө	гүйцэтгэл			
0	2	3	4	5	6	7	
1	Боловсруулах	ЦЭХ	мян.квтц	424,434.4	434,209.0	9,774.7	102.3
		ДЭХ	Гкал	687,657.0	699,004.8	11,347.8	101.7
	ДХЦЭХ	хувиар	%	14.3	14.1	(0.2)	98.3
		биетээр	мян.квтц	60,879.0	61,202.4	323.4	100.5
	Түгээх	ЦЭХ	мян.квтц	363,555.3	373,006.7	9,451.4	102.6
ДЭХ		Гкал	664,257.0	678,773.8	14,516.8	102.2	
2	Нийт орлого		Мян.төг	86,223,918.9	93,486,890.5	7,262,971.6	108.4
	Үүнээс :Борлуулалтын орлого		Мян.төг	68,530,296.5	75,144,338.7	6,614,042.2	109.7
	Татаасын орлого			6,806,371.8	6,806,371.8	0.0	100.0
	үйл ажиллагааны бус орлого		Мян.төг	10,887,250.6	11,536,180.0	648,929.4	106.0
3	Нийт зардал		Мян.төг	92,113,395.5	89,547,388.7	(2,566,006.7)	97.2
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		Мян.төг	82,024,323.1	81,922,800.8	(101,522.2)	99.9
	Үйл ажиллагааны бус зардал		Мян.төг	10,089,072.4	7,624,587.9	(2,464,484.5)	75.6
	ҮХ элэгдлийн зардал		Мян.төг	13,506,125.7	13,523,979.6	17,853.9	100.1
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		Мян.төг	(5,889,476.6)	3,939,501.8	9,828,978.4	(66.9)
5	Татварын дараах ашиг /алдагдал/		Мян.төг	(5,889,476.6)	3,939,336.90	9,828,813.5	(66.9)
6	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал		Мян.төг	1.1	1.0	(0.1)	91.8
7	Нийт авлага		Мян.төг	3,980,600.0	4,303,295.4	322,695.4	108.1
	Үүнээс:	ЭХ-ний	Мян.төг	3,231,000.0	3,928,276.6	697,276.6	121.6
		Бусад	Мян.төг	749,600.0	375,018.8	(374,581.2)	50.0
8	Нийт өглөг		Мян.төг	88,195,600.0	82,262,838.1	(5,932,761.9)	93.3
	Үүнээс:	Урт хугацаат өр	Мян.төг	67,950,100.0	63,753,302.7	(4,196,797.3)	93.8
		Богино хугацаат өр	Мян.төг	20,245,500.0	15,517,535.9	(4,727,964.1)	76.6
Урьдчилж орсон орлого Бойлерийн байг-ж					2,991,999.5	2,991,999.5	-
9	Нийт ажиллагсдын тоо		хүн	474.0	475.0	1.0	100.2
10	Нийт цалингийн сан		Мян.төг	20,839,300.0	19,836,014.8	(1,003,285.2)	95.2
11	Жишмэл түлшний зарцуулалт	ЦЭХ	гр/кВтц	432.3	432.2	(0.1)	100.0
		ДЭХ	кг/Гкал	190.2	187.5	(2.7)	98.6
12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт		Мян.төг	8,567,900.0	10,077,502.7	1,509,602.7	117.6



### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Компани, түүний үйл ажиллагаа**

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь тусгай зөвшөөрлийн хүрээнд цахилгаан, дулааны эрчим хүч боловсруулж, Дархан хотыг бүхэлд нь хэрэгцээний халуун ус, дулаанаар хангахаас гадна томоохон үйлдвэрүүдийг технологийн хэрэгцээний уураар хангах үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

#### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай, Эрчим хүчний тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Компанийн гүйцэтгэх захирал зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дотоод хяналтын нэгж санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянадаг байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,012,465.6 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	332,930.6	327,079.8	(5,850.8)
Дансны авлага	3,343,605.9	3,928,276.6	584,670.7
Татвар, НДШ-ийн авлага	473,679.9	374,064.7	(99,615.3)
Бусад авлага	191,517.4	954.1	(190,563.3)
Бараа материал	7,317,321.9	6,507,375.7	(809,946.2)
Урьдчилж төлсөн зардал тооцоо	523,512.6	832,056.5	308,543.9
Үндсэн хөрөнгө	129,418,807.5	130,895,986.5	1,477,179.1
Биет бус хөрөнгө	25,288,408.5	25,036,455.9	(251,952.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>166,889,784.2</b>	<b>167,902,249.8</b>	<b>1,012,465.6</b>
Богино хугацаат өр төлбөр	7,216,757.6	18,509,535.4	11,292,777.9
Урт хугацаат өр төлбөр	80,548,254.5	63,753,302.7	(16,794,951.9)
Эздийн өмчийн дүн	79,124,772.1	85,639,411.7	6,514,639.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>166,889,784.2</b>	<b>167,902,249.8</b>	<b>1,012,465.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 5,850.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны зарцуулалттай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 4,303,295.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 294,492.2 мянган төгрөгөөр өсөхөд “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аас авах авлагын өсөлт голлон нөлөөлсөн байна. Тодруулбал авлагын 91.0 хувь буюу 3,916,935.5 мянган төгрөг нь “Диспетчерийн үндэсний төв” ХХК-аас авах авлага байгаа бол 8.6 хувь буюу 374,064.7 мянган төгрөг нь НӨАТ, НДШ-ийн авлага эзэлж байна.

Бараа материалын данс 809,946.2 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар буурсан нь тайлант онд ЦЭХ, ДЭХ-ний үйлдвэрлэл өссөнтэй холбоотойгоор бараа материалын зарцуулалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Урьдчилж төлсөн зардал данс 308,543.9 мянган төгрөгөөр буюу 58.9 хувиар өссөн нь бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа төлбөр 182,960.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, замд яваа нүүрс тээврийн зардал 125,575.9 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Тодруулбал нүүрс тээврийн зардалд “Улаанбаатар төмөр зам” ХНН-д өмнөх онд 213,126.1 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлснийг тайлант онд 174,657.4 мянган төгрөгөөр нэмж, ОХУ-ын “Калугын турбин завод” нээлттэй хувьцаат компанид сэлбэгийн урьдчилгаа 155,820.5 мянган төгрөг төлсөн байна.

Үндсэн хөрөнгө данс 1,225,226.5 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тодруулбал тайлант онд худалдан авсан 521,388.2 мянган төгрөг, их засварын капиталжуулалтаар 9,721,016.6 мянган төгрөг, дахин үнэлсэн 1,028,749.8 мянган төгрөг, данс хооронд шилжүүлсэн 13,149,053.5 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүлээн авсан 2,276,805.6 мянган төгрөг, нийт

26,697,013.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, ТӨБЗГ-ын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 339 тоот тогтоолоор 290,669.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, ТӨБЗГ-ын 2024 оны 442 дугаар тогтоолоор 133,955.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-д шилжүүлж, данс хооронд 13,496,698.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 13,240,371.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Богино хугацаат өр төлбөр 11,292,777.9 мянган төгрөгөөр буюу 156.5 хувийн өсөлт нь Турбин-5 төслийн зээл, зээлийн хүүгийн өр 10,096,164.6 мянган төгрөг, шугаман зээлийн өглөг 595,971.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Харин урт хугацаат өр төлбөр 16,794,951.9 мянган төгрөгөөр буурахад Турбин-5 төслийн зээл, зээлийн хүүгийн тайлант оны өрийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмчийн дүн 85,639,411.7 мянган төгрөг болж 6,514,639.6 мянган төгрөгөөр өсөхөд өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэж 2,718,692.8 мянган төгрөг үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, мөн тайлант үеийн ашиг алдагдал, голлон нөлөөлжээ.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь компанийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/12 тоот тушаалаар компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 80,420,497.8 мянган төгрөгөөр, нийт зардлыг 91,531,575.4 мянган төгрөгөөр, 11,111,077.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тооцсон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 8,567,900.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Эрчим хүчний сайдын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/288 дугаар тушаалаар тодотгол хийж, орлогыг 5,803,421.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 86,223,918.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 581,820.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 92,113,395.5 мянган төгрөгөөр, алдагдлыг 5,221,601.0 мянган төгрөгөөр бууруулж, 5,889,476.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар тодотгосон байна. Харин хөрөнгө оруулалтын арга хэмжээний зардалд өөрчлөлт ороогүй байна.

Гүйцэтгэлээр 93,486,890.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 89,547,388.7 мянган төгрөгийн зардал гарган, 3,939,501.8 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 93,486,890.5 мянган төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөг 7,262,975.3 мянган төгрөгөөр буюу 108.4 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ

нь ЭХЗХ-ны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор тарифт өөрчлөлт орсноор борлуулалтын орлого 6,614,045.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 6,806,371.8 мянган төгрөгийн татаас авч тарифын дутагдлаа нөхсөн, үндсэн бус үйл ажиллагааны орлого 648,929.4 мянган төгрөгөөр давж биелсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 89,547,388.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 2,566,007.5 мянган төгрөг буюу 2.7 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна. Үүнд валютын ханшны 2,515,964.6 мянган төгрөгийн бодит бус алдагдал гол нөлөө үзүүлжээ.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 127 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 10,077,502.7 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 5,889,481.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснийг 9,828,982.8 мянган төгрөгөөр бууруулж, 3,939,501.8 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахад борлуулалтын орлогын өсөлт, татаас санхүүжилтын орлого голлон нөлөөлжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Санжаажав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 1/109 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан зардлын 92,113,395.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 921,133.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан боловч хуулиар хориглосон зарим зардлыг гаргасан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад орлогын 78,586,036.2 мянган төгрөгийн 1,121, зарлагын 63,674,444.9 мянган төгрөгийн 1,194 гүйлгээг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Худалдан авах ажиллагааны тухай

Тус станц нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨБАҮХА тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Тайлант онд 13,628,737.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 128 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 12,777,368.8 мянган төгрөгийн 127 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд худалдан авах ажиллагааг ТБОНӨБАҮХА тухай хуульд нийцүүлэн зохион байгуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 153,139.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
				Хувь	
Зөвлөмж	3	153,139.1	3	153,139.1	100.0
Нийт дүн	3	153,139.1	3	153,139.1	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,589.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илрүүлж 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд 2023-2024 оны өвлийн их ачааллыг амжилттай даван туулахад идэвх зүтгэл гаргаж ажилласан гэх үндэслэлээр компанийн эмэгтэй ажилчдыг Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан 18,315.0 мянган төгрөгөөр шагнасан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д *“хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно;”*, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д *“Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна”* гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.
- Диспетчерийн үндэсний төв үүсэж хөгжсөний 60 жилийн ойг тохиолдуулан тус байгууллагын 3 ахмад ажилтанд нийт 1,050.0 мянган төгрөгийн шагнал олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д *“хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно;”*, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8-д *“Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна”* гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

- Тайлант онд тус компанийн ерөнхий инженерээр ажиллаж байсан Б.Хаш-Эрдэнэд 4,224.0 төгрөгийн шагналыг давхардуулан олгосон байна. Энэ Компанийн 2024 оны хамтын гэрээний 5 дугаар бүлгийн 5.22-д *“Эрчим хүчний салбарт үр бүтээлтэй ажилласан ажилтнуудын нэг удаагийн мөнгөн шагналыг салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцон урамшуулал олгоно”*, Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 13 дугаар бүлгийн 13.2-д *“Ажилтанд нийгмийн хамгааллын чиглэлээр үзүүлэх тусламж, дэмжлэг, хөнгөлөлт, олгох тэтгэмж, шагнал урамшууллыг хамтын гэрээгээр зохицуулна”* гэж заасантай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

- Зөвлөмж өгөх алдаа, зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 2023-2024 оны өвлийн их ачааллыг амжилттай даван туулахад идэвх зүтгэл гаргаж ажилласан гэх үндэслэлээр компанийн эмэгтэй ажилчдад Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах едөрт зориулан 18,315,000.00 төгрөгөөр шагнасан байна	1	18,315.0	1	18,315.0								
Диспетчерийн үндэсний төв үүсэж хөгжсөний 60 жилийн ойг тохиолдуулан тус байгууллагын 3 ахмад ажилтанд нийт 1,050,000.00 төгрөгийн шагнал олгосон байна	1	1,050.0	1	1,050.0								
Тайлант онд тус компанийн ерөнхий инженерээр ажиллаж байсан Б.Хаш-Эрдэнэд 4,224,000.00 төгрөгийн шагнал давхардуулан олгосон байна	1	4,224.0			1	4,224.0						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>23,589.0</b>	<b>2</b>	<b>19,365.0</b>	<b>1</b>	<b>4,224.0</b>						

ХТ05130098072399